



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 08 сарын 08 өдөр

Дугаар А/365

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалын 2 дугаар зүйлийн 2.1.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 79 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсын шинэ Үндсэн хуулиар баталгаажсан Нутгийн өөрөө удирдах байгууллага үүсч хөгжсөний 25 жилийн ойг Орхон аймагт тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааны зардалд 10.000.000 /арван сая/ төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх 10.000.000 /арван сая / төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.



ЗАСАГ ДАРГА

Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 48 дугаар захирамжийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН ШИНЭ ҮНДСЭН ХУУЛИАР БАТАЛГААЖСАН
НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГА ҮҮСЧ ХӨГЖСӨНИЙ
25 ЖИЛИЙН ОЙГ ОРХОН АЙМАГТ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

Д/Д	Зардлын тооцоо	Шаардагдах хөрөнгө /мян.төг/
1	25 жилийн түүхчилсэн товхимол бэлтгэж хэвлүүлэх	5.000.000
2	Аймгийн ИТХ-ын байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах	5.000.000
	Нийт дүн	10.000.000